



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР

2013 оны Санхүүгийн Тайлан

Төв аймгийн Аудитын газар нь Төрийн Аудитын тухай хуульд заасан Аймгийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд улсын болон орон нутгийн төсвөөс санхүүждэг төсөвт байгууллагын санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим холбогдох хууль, журам зааварт нийцүүлэн аудит хийж байна.

Аудитыг дуусгавар болгосон тухай тайлан

АГУУЛГА

ХУУДАС

Лавлах зүйлс байвал доорх хаягаар холбоо барина уу:

Аймгийн Ерөнхий Аудитор

Л.Жаргалсайхан

Утас: 22582

[И-мэйл](#)

Аудитор

О.Сосор

Утас: 23204

И-мэйл

ТӨАГ-ын хаягийг оруулах

Төв аймаг Зуунмод сум 1-р баг Төрийн
байгууллагуудын ордон

• Танилцуулга	3
• Санхүүгийн дотоод хяналт	3
• Гол шийдлүүд	4
• Залруулаагүй алдаа	4
• Тайлбар мэдүүлгийн захидал.....	4
• Аудитын санал дүгнэлт	4

Мэргэжлийн Хяналтын Газрын 2013 оны Санхүүгийн Тайланд ААГ аудит хийж дууссан тухай мэдэгдэл

Бид Мэргэжлийн Хяналтын Газрын 2013 оны Санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Мэргэжлийн хяналтын газрын Төсвийн Ерөнхийлөн захирагчид энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Бид Мэргэжлийн хяналтын газрын Удирдлага тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.

Удирдлагын зөвлөлийн анхаарлыг дараах зүйлд чиглүүлж байна:

- Гол санхүүгийн хяналтууд хамрагдсаныг **тодруулбал:**

НББ-ийн үе шат бүрд дээд шатны түвшний удирдлага хүрдэг эсэх, нийтлэг чанартай зардал, төсвийн санхүүжилт, өөрийн орлого, цалингийн зардал, өглөг, авлага, балансын үзүүлэлтүүд, үндсэн хөрөнгө, бараа материал, бусад асуудлуудыг хамруулсан бөгөөд байж болзошгүй эрсдлийг тооцож холбогдох батламж мэдэгдлүүд хэрхэн хангагдаж байгааг нотлох үүднээс холбогдох стандарт, журам зааврын дагуу шаардлагатай горимыг хэрэгжүүлсэн.

- Гол илрүүлсэн зүйлс аудитын үр дүнгээс гарсныг **тодруулбал:**

2013 онд МХГ-ын төсөв 615326.4 мянган төгрөгөөр батлагдсан. Тайлант онд батлагдсан төсвийг 22572.4 мянган төгрөгөөр бууруулж, улсын төсвөөс 592754.0 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 37180.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн. Төсөвт байгууллагын өөрийн орлого 1710.2 мянган төгрөг орсныг тайлан тэнцэлд бүрэн тусгасан байна.

Харилцах дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 37180.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлснийг мөнгөн гүйгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгээр зардалд бичилт хийсэн байсныг аудитын явцад тохируулгын тайланг гаргуулж авсан..

Тайлан тэнцлийг NAG-STAB программаар шалгаж үзэхэд 2012 оны үйл ажиллагааны нэмэлт орлого зарлагын хэмнэлтээс МХЕГ-аас шилжиж ирсэн 4000.0 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайланд орлогоор тусгаагүй байсныг аудитын явцад орлогоор бүртгэсэн.

- Программ хангамж 833,0 мянган төгрөгөөр дансанд бүртгэлтэй. Интер актив Би Ай ХХК-д Emerald программ ашигласны төлбөрт гэрээгээр жилд

198,0 мянган төгрөгийг төлж үргүй зардал гаргаж байна.

- Шатахууны зарцуулалтын байдлыг шалгах явцад МХГ-ын 2013.08.14 ны өдөр даргын тушаал гарган 812250 төгрөгийг аялал зугаалганд явахад зарцуулж төсвийн тухай хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулж төлөвлөх гэсэн заалтыг зөрчсөн байна
- ЕМ, Санхүүгийн албаны даргаас ААГ тайлбар мэдүүлэг хүлээж байгаа -Илэрсэн алдааг хэрхэн залруулсан талаар тайлбар ирүүлнэ үү
- Аудитыг дуусгаж аудитын явцад олж авсан ажлын баримтанд үндэслэн зөрчилгүй дүгнэлт гаргахаар Ерөнхий аудитор санал оруулсан байгаа
- Ерөнхий Аудитор 2014.01.21-н ы өдөр санал дүгнэлтэнд гарын үсэг зурна.

Эцэст нь аудитын явцад Ахлах нягтлан бодогч С.Одончимэг олон бусад бидэнтэй хамтран ажилласан ажиллагсдын байнгын дэмжлэг туслалцаа бидний ажилд дэмжлэг болж байсанд гүнээ талархаж байна.

Аудитор О.Сосор

Төв аймгийн Аудитын Газар

2014.01.21

Танилцуулга

1. Бид Мэргэжлийн Хяналтын Газрын 2013 оны 12 дугаар сарын 31-р тасалбар болсон санхүүгийн тайланд аудитаа хийж бараг дуусаж байгаа ба Мэргэжлийн Хяналтын Газрын даргад энэхүү аудит хийж дуусгах тухай мэдэгдлийг өргөн барьж улмаар энэхүү санхүүгийн тайланг дахин шалган нягталж бидэнд туслахыг хүсч байна. Удирдлагын захидал хэмээх тусдаа хэсэгт санхүүгийн хяналтыг сайжруулах талаарх бидний өгсөн зөвлөмжүүд орсон бөгөөд Мэргэжлийн Хяналтын Газрын тухайн зөвлөмж бүрд хариу явуулна уу.
2. Бидний 2013 онд тайланд хийсэн аудит нь 2 гол элементтэй:
 - Санхүүгийн хяналтын системийг дахин шалгах;
 - Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.Аудитаас үүдэн гарсан асуудлууд дараах хэсэгт хураангуйлагдсан.

Жилийн санхүүгийн тайланд аудит хийх.

3. ААГ санхүүгийн хяналтыг дахин шалгаж үзээд санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг баталгаажуулах шаардлагатайг авч үзсэн. Бидний дахин шалгалт нь Мэргэжлийн Хяналтын Газрын хяналтыг ААГ-ын санхүүгийн эрсдэл ба хяналтын мэдээтэй харьцуулан шинжлэн үзсэн. Үүний үр дүнд цаг ямагт үр өгөөжтэй материаллаг алдаанаас сэргийлж чадах гол санхүүгийн хяналтыг онцгойлон үзсэн юм. Бид Мэргэжлийн Хяналтын Газрын даргад тухайн жилийн эдгээр хяналтын асуудлын тухай тайлагнасан.

4. Дараахь түвшний хяналтын асуудал бидний дахин шалгалтын үр дүнгээс гарсан бөгөөд үүнд Мэргэжлийн Хяналтын Газрын удирдлагын анхаарлыг хандуулж байна.

1 .Орлого,санхүүжилтийн талаар

Батлагдсан төлөвлөгөөний дүнг төсвийн хэлбэлзэл, төсвийн гүйцэтгэлийн тайлантай тохирч буй эсэхийг шалгахад Зарцуулах эрх батлагдсан төсвийн дүнтэй тохирч байна.

Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан. 2013 онд Батлагдсан төлөвлөгөөний дүнг төсвийн хэлбэлзэл, төсвийн гүйцэтгэлийн тайлантай тохирч буй эсэхийг шалгахад Зарцуулах эрх батлагдсан төсвийн дүнтэй тохирч байна.

Орлого санхүүжилтыг тайлан тэнцэлд бүрэн тусгасныг тулган шалгасан. 2013 оны батлагдсан төсөв 615326.4 мянган төгрөгөөр батлагдсан.Тайлант онд төсвийг 22572.4 мянган төгрөгөөр бууруулж , 2013 онд улсын төсвөөс 592754.0 мянган төгрөгийн урсгал санхүүжилт авч, зарцуулагдаагүй үлдэгдэл 37180.5 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн. төсөвт байгууллагын өөрийн орлого 1710.2 мянган төгрөг орсныг тайлан тэнцэлд бүрэн тусгасан байна.

Харилцах дансны зарцуулагдаагүй үлдэгдэл 37180.5 мянган төгрөгийг төвлөрүүлэх шилжүүлгээр зардалд бичилт хийсэн байсныг аудитын явцад тохируулгын тайлан гаргуулж авсан.

Тайлан тэнцлийг NAG-STAB программаар шалгаж үзэхэд 2012 оны үйл ажиллагааны нэмэлт орлого зарлагын хэмнэлтээс МХЕГ-аас шилжиж ирсэн 4000.0 мянган төгрөгийг Мөнгөн гүйлгээний тайланд тусгаагүй байсныг аудитын явцад орлогоор бүргэсэн.

2.Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 904187.9 мянган төгрөг, тайлант онд үндсэн хөрөнгө нь 50812.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, данснаас 24431.2 мянган төгрөгийн хөрөнгө хасагдаж, оны эцэст 930569.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Хөрөнгийг хүлээн авсан акт шийдвэрийг үндэслэн дараахь хөрөнгийг холбогдох дансад орлогодсон байна.

Төрийн өмчийн хорооны 2013.07.05 ны өдрийн 447 тоот тогтоолоор МХЕГ-ын дансанд бүртгэлтэй аксент маркийн 68-30 УБС маркийн, 20573.8 мянган төгрөгийн дансны үнэтэй автомашиныг -1700.0 мянган төгрөгийн үнэтэй, люминар бокс Төв аймгийн МХГ-т баланснаас дансанд шилжүүлсэн байна. машин данс бүртгэлд тусгасан байна.

2013 оны 1-р улиралд BGR-ийн төслөөс МХГ-ын геологи, уул уурхайн хяналтанд ашиглуулахаар 10402.0 мянган төгрөгийн нарийн мэргэжлийн багаж ирснийг данс бүртгэлд бүрэн тусгасан байна.

Үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг МХГ-ын даргын 2013.12.12 ны өдрийн А/51 тоот тушаалаар 3 хүний бүрэлдхүүнтэй томилсон байна.Тооллогын комиссууд тооллогыг хийж тооллогын дүнг илтгэх хуудсаар танилцуулж, тооллогын бүртгэлийг хөтөлж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Тооллогын дүнгээс нягтлан үзэхэд 986.8 мянган төгрөгийн цаг бүртгэлийн программ бүртгэл тоног төхөөрөмжийн дансанд бүртгэлтэй байна.

Аймгийн ИТХТэргүүлэгчдийн 2013.10.15 ны өдрийн 95 тоот тогтоолоор 61 нэр төрлийн 20315.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 4115.7 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг акталж устгасан.

Программ хангамж 833,0 мянган төгрөгөөр дансанд бүртгэлтэй. Интер актив Би Ай ХХК-д Emerald программ ашигласны төлбөрт гэрээгээр жилд 198.0 мянган төгрөгийг төлж үргүй зардал гаргаж байна.

NAG-STAB аар тайлангийн уялдаа холбоог шалгахад Үндсэн хөрөнгийн элэгдэл тодруулгын тайланд 38024.1 мянган төгрөгийн зөрүүтэй байсныг аудитын явцад залруулсан. Бараа үйлчилгээнээс зардлаас 1745.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэн.Үндсэн хөрөнгийн элэгдлийг Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолын дагуу шулуун шугамын аргаар тооцсон байна.

Программ хангамж 833,0 мянган төгрөгөөр дансанд бүртгэлтэй. Интер актив Би Ай ХХК-д Emerald программ ашигласны төлбөрт гэрээгээр жилд 198,0 мянган төгрөгийг төлж байна. Аймгийн бүх төсөвт байгууллагууд Интер активын Acclous санхүүгийн программ ашигладаг. Программын үнэ төлөөд л бүх үйлчилгээг хийлгэдэг.Гэтэл Интер активын программ ашиглаад төлбөр төлж байгаа нь төсвийг үр ашиггүй зарцуулж байна.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг тооцохдоо Засгийн газрын 2005 оны 233-р тогтоолын дагуу шулуун шугамын аргаар тооцсон.

3.Бараа материал

Бараа материалын орлогын гүйлгээг харилцах данснаас шилжүүлсэн тохиолдолд авлага өглөгийн дансаар дамжуулан бүртгэсэн байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 20959.1 мянган төгрөг, орлого 33468.8 мянган төгрөг, зарлага 30125.5 мянган төгрөг гарч 24275.5 мянган төгрөгийн эцсийн үлдэгдэлтэй байна.

Бараа материал дансанд хөтлөгдөх анхан шатны баримтыг хэсэгчлэн шалгахад тайлан гаргалт, баримт бүрдүүлэлт орлого, зарлагын баримт, шаардах хуудас зэргийг зохих журмын дагуу холбогдох албан тушаалтан гарын үсэг тамга тэмдэг дарагдсан баримтын бүрдэл сайн байна.

Суудлын автомашины замын хуудсыг жолооч явсан тухай бүрд бичиж хариуцсан хэрэглэгчээр гарын үсэг зуруулсан байна. Эд хариуцагч нярав нь шатахууны тайланг сар бүр гаргаж хэвшсэн байна.

Сэлбэг хэрэгслийг авахдаа техникийн комиссын дүгнэлт гаргуулсаны дараа сэлбэгийг худалдан авч зарцуулж ,автомашины хувийн хэрэгт шинээр сольсон сэлбэг хэрэгслийг тухай бүрд нь бүрэн хөтөлсөн байна.

4.Цалингийн талаар

Цалингийн болон гэрээтийн цалингийн зардал Мөнгөн гүйлгээний тайланд 350013.3 мянган төгрөгөөр , санхүүгийн үр дүнгийн тайланд 350013.3 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

МХГазрын даргын 2013.01.03 ны өдрийн 01тоот тушаалаар ажилтан албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоосон.

МХГ нь 2013 онд нийт 48 орон тоо батлагдсанаас, гүйцэтгэлээр 44 орон тоогоор ажилласан байна. Цалингийн сан төлөвлөгөөгөөр 371195.1мянган төгрөг ,гүйцэтгэлээр 350013.3 мянган төгрөг зарцуулсан. Цалингийн сан 21181.8 мянган төгрөгийн хэмнэлттэй гарсан.

- Хүнсний эрүүл ахуйн улсын байцаагч,
- Хэмжил зүйн хяналтын улсын байцаагч
- Харилцаа холбоо мэдээллийн улсын байцаагч
- Санхүү хөдөлмөр нийгмийн хамгааллын улсын байцаагч гэсэн 4 орон тоо дутуу ажилласан байна.

Батлагдсан 48 орон тооноос 4 орон тоо дутуу ажилласнаас цалингийн сан 21181.7 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй гарсныг төсөвт төвлөрүүлсэн байна.

Байгууллагын дотоод журамд заасны дагуу цалингийн санд төлөвлөж ажиллагсад хоолны үнэнд өдөрт 1500 төгрөг бодож олгож, нийт 13255.6 мянган төгрөгийг олгосон байна.

Цалин хөлсний баримтыг шалгахад МХГ-ын даргын тушаалаар сахилгын арга хэмжээ тооцуулсан жижүүр О.Мөнхбатын цалингаас суутгасан 194916 төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй, мөн сахилгын арга хэмжээ тооцуулсан улсын байцаагч С.Ундрахбаатарын цалингийн 10 хувийн суутгал 50496 төгрөгийн суутгал хийгээгүй зөрчил илэрсэн.

5.Бараа үйлчилгээний зардал

Бараа ажил үйлчилгээний зардал нь төсвийн гүйцэтгэлийн тайлангаар төлөвлөгөөгөөр 101630.2 мянган төгрөг зарцуулахаас гүйцэтгэлээр 97908.9 мянган төгрөгөөр буюу 3721.2 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Томилолтын хуудсыг дугаарласан ,томилолтоор явсан мэргэжилтнүүд ажлын тайлангаа тогтмол бичиж томилолтын ард хавсаргасан баримтын бүрдэл сайн байна.

Шатахууны зарцуулалтын байдлыг шалгах явцад МХГ-ын 2013.08.14 ны өдөр даргын тушаал гарган 812250 төгрөгийг аялал зугаалганд явахад зарцуулж төсвийн тухай хуулийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар зарцуулж төлөвлөх гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шатахууны тайлан гаргалтын байдлыг шалгахад байгууллагын нярав нь харилцагч байгууллагаас шатахууныг талонаар авч нярав тайланг сар бүр гаргасан байна. Батлагдсан шатахууны зардал 17280.6 мянган төгрөг, тайлант онд 15790.0 мянган төгрөг зарцуулж 1490.0 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

6.Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдлийг хэсэгчлэн шалгахад мөнгөн хөрөнгөнд хөтлөгдөх анхан шатны баримтыг зохих журмын дагуу бүрдүүлсэн байна.

2012 оны үйл ажиллагааны нэмэлт орлого зарлагын хэмнэлтээс МХЕГ-аас шилжиж ирсэн 4000.0 мянган төгрөгийг МХГ-ын даргын 2013.12.23 ны өдрийн А/55 тоот тушаалаар үр дүнгийн урамшуулалд 3679.2 мянган төгрөгийг, түлш халаалтын зардалд 320.8 мянган төгрөгийг зарцуулах шийдвэр гаргаж ,төрийн санд нэмэлт төсвийн зарцуулалтын эрхийн хүсэлт гарган зарцуулсан байна.

Цалингийн сан, НДШ-ийн зарцуулаагүй үлдэгдэл 28568.6 мянган төгрөг, шатахууны хэмнэлт-1490,6мянган төгрөг, эм 2007.5мянган төгрөг, нийт 37180.5 мянган төгрөгийгсангийн яаманд буцаан төвлөрүүлсэн байна..

Төрийн сангаар гүйлгээ хийсэн баримт бүрт төрийн сангийн тэмдэг дарж баталгаажсан байна.

7.Авлага ,өглөгийн талаар

Авлага өглөгийн журналыг ерөнхий дэвтэрийн данстай тулган баталгаажуулсан.

- Төв Чандмань ДЭХГ-т халаалт болон цэвэр,бохир усны үнэнд нэхэмжлэхээр 37028.5 мянган төгрөгийн шилжүүлсэн байна.Төв чандмань ДЭХГ-аас ирүүлсэн тулган баталгаажуулалтаар 37028.5 мянган төгрөг төлж тооцооны үлдэгдэлгүй гарсан байна.
- Цахилгааны үнэнд 1805.6 мянган төгрөг нэхэмжлэхээр төлсөн.

Ажил гүйлгээг тухай бүрд нь өглөг, авлаг үүсгэн бүртгэсэн . Харилцагч байгууллагуудаас НДХэлтэс, Цогт-өлзийт ХХК, Мандухай цэцэн ХХК- тай тооцоо нийлж актыг үйлдсэн боловч тооцооны баримтын жагсаалт хийгээгүй байна.Тооцооны баримтыг тооцооны үлдэгдлийн баталгааны хавсралтанд нэгтгэн гаргахгүй байгаа нь нийт төлсөн мөнгө болон бэлтгэн нийлүүлэгч байгууллагын нэхэмжилсэн дүн тодорхой бус байна.

8. Санхүүгийн дотоод хяналтын талаар

Аймгийн МХГазрын даргын 2013.03.04-ний өдрийн А/18 тоот тушаалаар дотоод хяналт шалгалтын ажлын албыг шинэчлэн зохион байгуулж ажлын хэсгийн даргаар Дэд бүтэц,байгаль орчин,геологи уул уурхайн хяналтын хэлтсийн дарга,улсын ахлах байцаагч А.Мөнхтулгыг томилсон байна. Дотоод хяналт шалгалтын ажлын албанаас 2013 онд дотоод хяналт шалгалт хийх ажлын төлөвлөгөөг боловсруулан газрын даргаар батлуулсан байна.Батлагдсан төлөвлөгөөний дагуу 2013 оны 1-р улиралд

- МХГазрын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулах журамыг баталсан байна.
- Мөрдөгдөж байгаа хууль тогтоомж ,шинээр батлагдсан хууль эрхийн актыг судлуулах
- Захиргааны зөрчлийн хэрэг бүртгэх үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж ,шалгалт хийсэн тухай дүнг танилцуулсан байна.

Дотоод хяналт шалгалтын алба нь жилийн хийсэн ажлын тайланг авчирч шалгуулаагүй болно.

Аудитын явцад хийгдсэн гол шийдлүүд

5.Дараах хэсэгт Санхүүгийн тайлангийн аудит явцад гарсан гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэсэн.

6.Эдгээр асуудлуудыг ААГ болон Мэргэжлийн хяналтын газрын удирдлага авч үзэж хангалттайгаар шийдсэн. Бидний илрүүлсэн зүйлс болон дээрх санхүүгийн дотоод хяналтын талаар санал нь удирдлагын захидалд тусгагдсан байна. Санхүүгийн гүйлгээнүүд нь хүлээн зөвшөөрөхүйц зохицуулагдсаныг тэмдэглэсэн.

Залруулагдаагүй алдаа

7. Аудитын стандарт нь ААГ-г аудитын явцад илэрсэн тодорхой биш болон залруулагдаагүй алдаанд анхаарал тавихыг шаарддаг. Аудитаар залруулаагүй алдаа гараагүй болно.

Тайлбар мэдүүлгийн захидал

8. Аудитын үйл явцад ААГ хөндлөнгийн аудиторын хувьд удирдлагын зүгээс гаргасан баталгаанд тулгуурлах ёстой байсан ч хараат бус байдлын хувьд энэ батламжийг дагах нь зохистой байсангүй. Аудитын гүйцэтгэл бүрд /тайлбар мэдүүлгийн захидлаар/ санхүү бүртгэлийн ажилтанаас эдгээр баталгааг бичгээр баталгаажуулан олж авахыг хүсч байна.

Аудитын санал дүгнэлт

9. Аймгийн Аудитын газраас тус тайланд зөрчилгүй дүгнэлт гаргахаар санал оруулж байна.

Аймгийн Аудитын газар

2014.01.21